



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2013 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 250

Улаанбаатар хот

“Ердийн даатгалын компанийн даатгалын нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага”-ыг батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13.1.3, 14.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Ердийн даатгалын компанийн даатгалын нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах нөхцөл шаардлага”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэ журмыг 2013 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3. Энэ шаардлага шинэчлэн батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн “Ердийн даатгалын компанийн хөрөнгийн байршил, хөрөнгө оруулалт, түүнд тавигдах шаардлага” батлах тухай 170 дугаар тогтоолыг энэхүү тогтоолын 1-д заасан журам үйлчилж эхэлмэгц хүчингүй болсонд тооцсугай.

4. Батлагдсан журмын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Х. Бум-Эрдэнэ/-д даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

**ЕРДИЙН ДААТГАЛЫН КОМПАНИЙН ДААТГАЛЫН НӨӨЦ
САНГААС ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХЭД ТАВИГДАХ
ШААРДЛАГА**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь даатгагчийн даатгалын нөөц сангаас хийх хөрөнгө оруулалтыг оновчтой болгох, хөрөнгө оруулалтын ангилал тодорхойлох, хэмжээ хязгаарыг тогтоох замаар даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах, даатгагчийн мөнгөн хөрөнгийг хангалттай хүрэлцэхүйц, баталгаатай байлгахад оршино.

Хоёр. Хөрөнгө оруулалт хийхэд учирч болох эрсдэл

2.1. Даатгагч даатгалын нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхдээ учирч болох дараах үндсэн эрсдэлүүдийг тооцоолно:

2.1.1. Зах зээлийн эрсдэл. Зах зээлийн үнийн өөрчлөлтийн улмаас санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ болон ирээдүйн мөнгөн гүйлгээ хэлбэлзэх эрсдэл. Үүнд хүүгийн түвшний эрсдэл, валютын ханшийн эрсдэл болон бусад үнийн эрсдэл хамаарана.

2.1.2. Зээлийн эрсдэл. Үнэт цаас гаргагч, зээлдэгч, харилцагч түнш болон мэргэжлийн оролцогч байгууллагуудын зээлийн чанар буурах болон зээл хугацаандаа төлөгдөөгүйн улмаас даатгагч санхүүгийн хохирол амсах эрсдэлтэй. Энэ төрлийн эрсдэлд зээл төлөгдөхгүй байх, зээлийн чанар буурах, шууд бус зээл, эсвэл зээлийн тархалтын эрсдэл, төвлөрлийн эрсдэл зэрэг эрсдэлүүд орно.

2.1.3. Хөрөнгийн хөрвөх чадварын эрсдэл. Даатгуулагчдад их хэмжээний даатгалын нөхөн төлбөр олгох шаардлагатай тохиолдолд даатгагчийн хөрөнгийн хөрвөх чадвар хүрэлцэхгүйн улмаас бэлэн мөнгөний дутагдалд орох эрсдэлтэй. Ийм төрлийн эрсдэлд хөрвөх чадварын үнэлгээний эрсдэл, салбаруудад оруулсан хөрөнгийн хөрвөх чадварын эрсдэл, хөрөнгийн сангийн эрсдэл зэрэг эрсдэлүүд орно.

2.2. Даатгагчид энэ журмын 2.1-д заасан эрсдэлүүдийг удирдахад дараах шаардлага тавигдана:

2.2.1. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөндөө эрсдэлийг удирдах бодлого, стратегийг тусгаж хэрэгжүүлэх;

2.2.2. Энэ журмын 2.2.1-д заасан бодлого, стратегийн дагуу хөрөнгө оруулалт хийхэд шаардлагатай арга замыг оновчтой сонгож, шалгарсан менежментийг хэрэгжүүлэх;

2.2.3. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг үнэлэх, хянах, тайлагнахад тохиромжтой тогтолцоог бүрдүүлсэн байх. /Тухайлбал, Дотоод хяналтын нэгжийн чиг үүрэгт оруулах гэх мэт/

2.3. Хорооноос энэ журмын 2.2-т заасан даатгагчийн хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа, даатгагчийн хөрөнгө оруулалтын эрсдэлийн тооцоолол, эрсдэлийн үнэлгээний аргачлал, хяналтын болон тайлагналын горим зэрэгт хяналт тавина.

Гурав. Холбогдох этгээд болон түүнтэй холбоотой этгээд буюу хөрөнгө оруулалтын хязгаарлалт

3.1. Нөөц сангаас Даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан хязгаарлалтаас гадна дараах этгээдэд хөрөнгө оруулалт хийхийг хязгаарлах бөгөөд энэхүү этгээд нь нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд эрсдэл бүхий этгээдэд тооцогдоно:

3.1.1. даатгалын тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасан холбогдох этгээд;

3.1.2. даатгагчийн болон холбогдох этгээдийн хувь нийлүүлэгч болон хувьцаа эзэмшигч;

3.1.3. даатгалын компанийн хувь нийлүүлэгч, ТУЗ-ийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал, даатгалын салбарын захирал, тэдгээрийн өвөг эцэг, эмэг эх, эцэг, эх, эхнэр, нөхөр, ах, эгч, дүү, хүүхэд болон тэдэнд хяналтын багцаа эзэмшүүлдэг хуулийн этгээд, уг хуулийн этгээдийн хяналтын багцыг эзэмшдэг аливаа иргэн, хуулийн этгээд;

3.1.4. барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэлгээ нь зээлийн үндсэн өр болон хүүгийн төлбөрийг барагдуулахад хүрэлцэхгүй байгаа иргэн, хуулийн этгээд;

3.1.5. холбогдох этгээдтэй хэрэг, маргаан үүссэний улмаас эрх бүхий байгууллагаар хянагдаж, шалгагдаж байгаа этгээд;

3.1.6. тухайн даатгалын компанийн даатгуулагч;

3.1.7. даатгалын компани өөрөө холбогдох этгээд гэж үзсэн бусад этгээд.

Дөрөв. Хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага

4.1. Даатгагч нь даатгалын нөөц сангаас хөрөнгө оруулалт хийх төлөвлөгөөтэй байх бөгөөд уг төлөвлөгөө нь энэ журмын 5.1-д заасан шаардлагыг хангасан байна.

4.2. Даатгагч нь даатгалын нөөц сангаас хөрөнгө оруулалт хийх төлөвлөгөөгөө жил бүрийн 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хороонд ирүүлж байна.

4.3. Хөрөнгө оруулалт хийх төлөвлөгөөг энэ журмын 5.1-д заасан хязгаарлалтын хүрээнд боловсруулсан байх;

4.4. Даатгагч нь гадаад улсад хөрөнгө оруулалт хийх бол Хороонд хүсэлтээ бичгээр тавина;

4.5. Даатгагч нь Хорооноос бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр гадаад улсад хөрөнгө оруулалт хийж болно.

4.6. Даатгагчийн гүйцэтгэх удирдлага нь зөвхөн ТУЗ-ийн хурлаар баталсан хөрөнгө оруулалт хийх төлөвлөгөөний дагуу хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг явуулна.

4.7. ТУЗ нь даатгалын холбогдох хууль, журмын биелэлт болон хөрөнгө байршуулах төлөвлөгөөний гүйцэтгэл, эрсдэлийн удирдлага, мэдээлэл, дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл болон хөндлөнгийн аудитын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллана.

4.8. Энэ журмын 5.1-д зааснаас бусад хэлбэрээр даатгагчийн нөөц сангийн хөрөнгөөс хөрөнгө оруулалт хийж бусад хэлбэрээр байршуулахыг хориглоно.

Тав. Нөөц сангийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх ангилал, хувь хэмжээ

5.1. Даатгагч даатгалын нөөц сангаас хөрөнгө оруулалт хийж, хөрөнгөө байршуулахдаа дараах ангилал, хэмжээ хязгаарт нийцүүлнэ:[Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 498 дугаар тогтоолоор нэмэлт орсон/](#)

Хөрөнгийн ангилал	Хөрөнгө оруулах дээд хувь
Баганын дүн	1
5.1.1. Засгийн газраас гаргасан өрийн хэрэгсэл	100%
5.1.2. Төв банкны үнэт цаас /Монгол банкны мөнгөний бодлогын нээлттэй захын хэрэгсэл бөгөөд хямдруулсан хэлбэрээр арилжигдаж, тогтоосон хугацааны дараа нэрлэсэн үнээр эргэн төлөгдөх үнэт цаасыг ойлгоно/;	100%
5.1.3. Санхүүгийн түрээс/Санхүүгийн түрээсийн тухай хуулийн 3.1, 3.2-т заасныг ойлгоно/	10%
5.1.4. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас/Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасныг ойлгоно/	60%
5.1.5. Холбогдох этгээд болон түүнтэй холбоотой этгээдээс бусад этгээдэд үл хөдлөх хөрөнгөөр барьцаалсан богино /1 жил хүртэл/ хугацаат зээл /Энэ журмын 3 дугаар зүйлд заасан этгээдийг ойлгоно/	20%
5.1.6. Аймаг нийслэлийн гаргасан өрийн хэрэгсэл	60%
5.1.7. Компанийн өрийн хэрэгсэл /Хорооноос тусгай зөвшөөрөл авсан даатгагчийн холбогдох этгээдээс бусад компанийн өрийн хэрэгслийг ойлгоно./	20%
5.1.8. МХБ-ийн “А” самбарын компанийн хувьцаа /энэ нь нэг компанийн гаргасан хувьцааны нийт дүнгийн 10%-иас дээшгүй байна/	10%
5.1.9. Тухайн даатгалын компанийн холбогдох этгээдэд үл хамаарах банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулах мөнгөн хөрөнгө	5%
Нийт нөөцийн сан	

5.2. Даатгагч хөрөнгө оруулах хэмжээг тооцохдоо даатгалын нөөц сангийн дүнг харгалзах хөрөнгө байршуулах хувиар үржүүлж тодорхойлно.

Зургаа. Хяналт тавих

6.1. Даатгагчийн нөөцийн сангийн хөрөнгө оруулалтад Хороо улирал бүр санхүүгийн тайланг үндэслэн хяналт тавина.

6.2. Даатгагч хөрөнгө оруулалт хийсэн тайлангаа энэ тогтоолын хавсралт “Маягт-1”-ээр гаргаж улирал бүр гаргаж санхүүгийн тайлангын хамт Хороонд ирүүлнэ.

6.3 Хороо энэ журмын хэрэгжилтэд хяналт тавих бөгөөд зөрчсөн этгээдэд Даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--ooOoo--

“Ердийн даатгагчийн нөөц сангаас хийх хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага”-ын хавсралт
“Маягт-1”

//Энэ маягтад Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 498 дугаар тогтоолоор нэмэлт орсон/

Даатгалын компанийн нөөц сангийн хөрөнгө оруулалтын тайлан

Хөрөнгийн ангилал	Даатгалын нөөц сангийн хөрөнгө оруулалтын дээд хувь	Даатгалын нөөц сангийн хөрөнгө оруулалтын дээд хэмжээ	Даатгалын нөөцийн сангийн хөрөнгө оруулалт
Баганын дүн	1		
1 Засгийн газраас гаргасан өрийн хэрэгсэл	100%		
2 Төв банкны үнэт цаас	100%		
3 Санхүүгийн түрээс	10%		
4 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	60%		
5 Холбогдох этгээдээс бусад этгээдэд үл хөдлөх хөрөнгөөр барьцаалсан богино хугацаат зээл	20%		
6 Аймаг нийслэлийн гаргасан өрийн хэрэгсэл	60%		
7 Компанийн бонд	20%		
8. МХБ-ийн “А” самбарын компанийн хувьцаа /энэ нь нэг компанийн гаргасан хувьцааны нийт дүнгийн 10%-иас дээшгүй байна/	10%		
9. Тухайн даатгалын компанийн холбогдох этгээдэд үл хамаарах банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулах мөнгөн хөрөнгө	5%		
Хөрөнгө оруулалтын дүн			

Жич: Даатгагчийн даатгалын нөөцийн сангийн нийт дүнгээс хөрөнгө оруулах дүнг хассан үлдэгдэл нь мөнгөн хөрөнгөөр байршина.

--oo00oo--

